



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 427

Улаанбаатар хот

“Монголын төмөр зам” төрийн өмчит
хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтэц,
орон тооны дээд хязгаарыг шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар сарын 62.1.15, 62.1.16 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтцийн схемийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн орон тооны дээд хязгаарыг 599 /Таван зуун ерэн ес/ байхаар тогтоосугай.

3. “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн зохион байгуулалтын бүтцийн схем, орон тооны дээд хязгаарт багтаан чиг үүрэг, албан тушаалын жагсаалт баталж, үйл ажиллагаа явуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Отгонсүх)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 379 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 427 дугаар тогтоолын хавсралт

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН СХЕМ

Нийт орон тоо: 599

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ажлын алба

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Хяналтын алба

Ерөнхий инженер

Төмөр замын үйл ажиллагаа, удирдлагын газар

Тээвэр, ложистикийн төлөвлөлтийн газар

Төсөл хөтөлбөр, судалгааны газар

Эдийн засаг, хөрөнгө оруулалтын газар

Захиргаа, удирдлагын газар

Суурь бүтцийн хэлтэс

Инженер технологийн хэлтэс

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хэлтэс

Хөдөлгөөн нөөхон байгуулалтын хэлтэс

Ачаа тээврийн хэлтэс

Цогцэций өртөө /Зангилаа/

Төмөртэй өртөө

Төслийн хэлтэс

Судалгаа, зураг төслийн хэлтэс

Төлөвлөлтийн хэлтэс

Статистик, мэдээлэл технологийн хэлтэс

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн хэлтэс

Хүний нөөц, сургалтын хэлтэс

Гадаад харилцаа, олон нийтий харилцаа хэлтэс

Худалдан авалтын хэлтэс

Хуулийн хэлтэс